

## **Говь-Алтай, Баянхонгор аймагт “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” сургалт зохион байгуулагдлаа.**

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын орлогч даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч Т.Цэрэнбадрал, Банк бус санхүүгийн байгууллагын ахлах референт А.Баянмөнх, Даатгалын газрын ахлах мэргэжилтэн Ц.Дашням нар 2018 оны 5 дугаар сарын 11-21-ний өдрүүдэд Говь-Алтай, Баянхонгор аймагт томилолтоор ажиллаж “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” сургалтыг Монголбанк, Бичил санхүүгийн хөгжлийн сан, БСШУСЯ-ны харьяа Говь-алтай, Баянхонгор аймаг дахь Насан туршийн боловсролын төв болон тухайн дахь Монголбанкны салбаруудтай хамтран зохион байгуулав.

Томилолтын гол зорилго нь “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” сургалт болон тухайн аймгийн засаг даргын тамгын газар, арилжааны банкны төлөөлөл, сэтгүүлчдэд чиглэсэн зорилтод сургалтууд зохион байгуулах байсан.

2018 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Говь-Алтай аймгийн, 2018 оны 5 дугаар сарын 18-ний өдөр Баянхонгор аймгийн орон нутгийн төр, захиргаа, Монголбанкны салбар болон арилжааны банкны ажилтнуудад “Санхүүгийн боловсрол гэж юу вэ?”, “Төр хувийн хэвшлийн оруулах хувь нэмэр”, “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах?”, “Хөрөнгө оруулалт ба үнэт цаас”, “Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн байдал” зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийв. Сургалтанд хоёр аймгийн санхүүгийн салбарын 60 орчим албан хаагчид хамрагдав.

2018 оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Говь-Алтай аймаг дахь “Насан туршийн боловсролын төв”-ийн 26 сургагч багш нарт, 2018 оны 5 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Баянхонгор аймаг дахь “Насан туршийн боловсролын төв”-ийн 27 сургагч багш нарт “Банк санхүүгийн байгууллага”, “Эрсдэл, эрсдэлээс хамгаалах арга”, “Даатгал”, “Хөрөнгө оруулалт ба үнэт цаас”, “Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн байдал” зэрэг сэдвүүдээр хичээл зааж, орон нутгийн сургагч багш нарт дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

Томилолтын үеэр орон нутгийн сэтгүүлчидтэй уулзалт хийж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан “Санхүүгийн боловсрол олгох”, “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” нь сэдвээр мэдээлэл хийж, иргэд олон нийтэд санхүүгийн мэдээллийг хэрхэн ойлгомжтой хүртээмжтэй хүргэх талаар харилцан санал бодлоо солилцож, Говь-Алтай аймгийн “Миний нутаг” ТВ, “Их Алтайн мэдээ” сонин, “Алтай” радио, Баянхонгор аймгийн “Хонгор”, “Мазаалай” телевизүүдэд ярилцлага, мэдээ өглөө.

Сургалтын үеэр явуулсан санал асуулгаас үзэхэд орон нутгийн иргэдэд Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа болон бичил санхүү, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын чиглэлийн хичээл, мэдээлэл чухал ач холбогдолтой, тэдний сонирхолыг татаж байгаа нь ажиглагдаж байлаа.



